



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

20220228 № 05/2727

танай -ны № -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төсвийн ерөнхий нягтлан бодогчоор томилогодооор нэр дэвшсэн Сүхбатын Лхам, Судалгаа, шинжилгээний хэлтсийн даргаар томилогодооор нэр дэвшсэн Цогтсайханы Мөнхсайхан, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар томилогодооор нэр дэвшсэн Пүрэв-Очирын Дэлгэрмаа, Хуулийн хэлтсийн даргаар томилогодооор нэр дэвшсэн Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, мөн хэлтсийн хууль, өргөдөл гомдол, тогтоол шийдвэрийн тайлан хариуцсан мэргэжилтнээр томилогодооор нэр дэвшсэн Мөнх-Эрдэнийн Ану-Үжин нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.


Нэр дэвшигч Ц.Мөнхсайхан нь албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагын "мэдээлэл, харилцаа, холбооны технологи, математик, статистик мэргэжилтэй байх, мэргэжлээрээ 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан туршлагатай байх" гэснийг хангаагүй тул Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн томилно уу.

Түүнчлэн Ц.Мөнхсайхан нь "Моннар спортс холдинг" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар бүртгэлтэй байх тул "Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг баримтлан ажиллах нь зүйтэй.

Нэр дэвшигч нар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үссэн, үсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142203004141